БАТЛАВ.
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.МӨНХЗУЛ

ӨГӨГДЛИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТЫН АЖЛЫН ДААЛГАВАР

Д/д	Агуулга	Тайлбар
1.	Зорилго	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн "2.1.2.6.Ядуурал, ажилгүйдэл болон хүн амын амьжиргааны түвшнийг тооцох аргачлалыг үндэсний онцлогт нийцүүлж, их өгөгдөл, хиймэл оюун ухаанд суурилан шинэчилнэ", "2.1.3.2.Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, их өгөгдөлд тулгуурлан, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран цахимаар авах боломжийг бүрдүүлнэ", "2.2.1.3.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг их өгөгдөлд суурилан тооцоолж, шаардлагатай хүний нөөцийг бэлтгэнэ" гэж тус тус заасан. Энэ хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын бодлогыг оновчтой төлөвлөн хэрэгжүүлэх зорилгоор салбарын мэдээллийн сангуудыг нэгтгэсэн их өгөгдлийн эко системийг бүрдүүлэх, түүнд цугларсан өгөгдөл, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, их өгөгдлийг үр ашигтайгаар ашиглах шаардлагатай байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь салбарын хэмжээнд их өгөгдлийн экосистемийг боловсруулах, хэрэгжүүлэх төслийг эхлүүлж байгаа бөгөөд уг систем дараах зорилготой. Үүнд: • Яам, агентлагуудын өгөгдлийг төвлөрүүлж, бодлогын гол чиглэлүүдэд 360 дүн шинжилгээ хийх шийдэл хэрэгжүүлнэ. • Олон улсын жишиг аргачлал ашиглан гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын гол үзүүлэлтүүдээр дүн шинжилгээ хийж хэрэгжүүлж салбарын бодлого боловсруулалтад дэмжлэг үзүүлнэ. • Өрхийн амьжиргааны түвшин тогтоох аргачлал боловсруулахад ашиглана.
2.	Захиалагч байгууллага	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
3.	Үзүүлэх үйлчилгээ	**Их өгөгдлийн дэд бүтэц боловсруулах, хэрэгжүүлэх** • ГБХНХЯ болон харьяа агентлагуудын өгөгдлийн экосистемийг үнэлэх;

		• Өгөгдлийн төвлөрүүлэн дүн шинжилгээ хийхэд тохирсон аюулгүй, өргөтгөх боломжтой зохион байгуулалтыг боловсруулж хэрэгжүүлэх;
		• Дараах байгууллагуудын өгөгдлийг нэгтгэх:
		  ○ Нийгмийн даатгалын ерөнхий газар (үндсэн болон дэд системүүд)
		  ○ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (eJob, eHalamj)
		  ○ Үндэсний статистикийн хороо, Боловсролын яам, бусад шаардлагатай гуравдагч этгээдүүд
		• ETL/ELT автомат дата зөөвөрлөх систем, дата лэйк үүсгэх, мета өгөгдлийн бүртгэл, өгөгдөл хаанаас үүссэн, хэрхэн өөрчлөгдсөн, хаашаа дамжсан, эцсийн хэрэглээнд хэрхэн ашиглагдаж буйг бүртгэж, хянах систем боловсруулах;
		• Өгөгдлийн цэвэрлэгээ, стандартчилал, давхардлыг арилгах дүрмийг хэрэгжүүлэх.
		Дараах гурван чиглэлд шаардлагатай үзүүлэлтүүдийг тодорхойлж бодит өгөгдөлд суурилан ахисан түвшний дүн шинжилгээ хийх загвар /системийн талбар/-ийг боловсруулж, үйл ажиллагаанд оруулах:
		• Гэр бүл
		  1. Гэр бүлийн үзүүлэлтүүд, түүний дүн шинжилгээ (Family Dynamics and Support)
		  2. Хүүхдийн хөгжил, хамгаалал (Child Development and Protection)
		  3. Орон сууц, гэр бүлийн байдал (Housing and Family Well-being)
		  4. Хүний хөгжил, амьдралын чанарын үзүүлэлтүүд, түүний дүн шинжилгээ (Human Development & Well-being)
		• Хөдөлмөр
		  5. Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт, түүний шинжилгээ (Labor Market Dynamics)
		  6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, хөдөлмөрийн эрхийн болон сонирхлын маргаан, хамтын гэрээ, хэлэлцээрийн мэдээлэл, түүний шинжилгээ (OSH)
		• Нийгмийн хамгаалал
		  7. Олон талт ядуурлын хэмжилт, шалгуур үзүүлэлтүүд (Multidimensional Poverty)
		  8. Халамжийн хүртээмж, үр дүнг тодорхойлох (Social Welfare and Social Protection)
		  9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний оролцоо ба хамгаалал (Disability Inclusion and Protection)
		  10. Нийгмийн даатгалын үзүүлэлтүүдийн үнэлгээ, салбарын үр дүн, Нийгмийн даатгалын хүртээмж, үр дүнг хэмжих үзүүлэлтүүд (Social Security Coverage)

		▪ Нийгмийн даатгалын хамралт (Ажиллах хүчинд ногдох даатгуулагчийн хувь, Бүртгэлтэй ажил олгогчид ногдох НД шимтгэл төлсөн ажил олгогчийн хувь)
		▪ ДНБ, төсвийн орлого, зарлагад эзлэх НДС орлого, зарлага.
		▪ Шимтгэл төлөгчид ногдох тэтгэвэр авагчийн тоо.
		▪ Орлого, зарлагатай холбоотой бүх үзүүлэлт нарийвчлах.
		▪ Шимтгэл, тэтгэврийн зохистой харьцааг тооцоолох.
		▪ Дэлхийн бусад оронд нийгмийн даатгалын талаар гаргаж буй үзүүлэлтийг нарийвчлах.
		• Дээрх чиглэлүүдийн хүрээнд одоо ашиглагдаж байгаа систем болон мэдээллийн санд хадгалагдаж байгаа датаны хүрээнд боловсруулна.
		Өгөгдлийн засаглал, нууцлал, харилцан уялдаатай байдал
		• Хувийн мэдээлэл хамгаалах хууль болон олон улсын ёс зүйн удирдамжид нийцсэн өгөгдлийн засаглалын бүтэц бий болгох;
		• Үүрэг хариуцлага, хандалтын түвшин, бүртгэл, ашиглалтын бодлого тодорхойлох;
		• Дата нийлүүлэгч эх үүсвэрийн мэдээллийн систем болон үндэсний мэдээллийн сантай уялдаатай болгох.
		Чадавх бэхжүүлэх арга хэмжээг зохион байгуулах
		• Сургалтын хөтөлбөрүүд зохион байгуулах:
		  ○ Системийн администрууд,
		  ○ Бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдад,
		  ○ Хэрэглэгчийн хүлээн авах тестийн оролцогчдод
		• Бүрэн баримтжуулсан материал хүлээлгэн өгөх: архитектур, ETL скрипт, хэрэглэгчийн гарын авлага, сургалтын материал
		Стратегийн шийдвэр гаргалтыг дэмжих
		• Байнгын шинэчлэгддэг хяналтын самбар, тайлан
		• Одоогийн өгөгдлийн засаглалын нөхцөл байдлын судалгаа, сайжруулах шийдлийн хувилбаруудыг боловсруулах
		• Бодлогын хэлэлцүүлэг, техникийн ажлын хэсэгт оролцох

4.	Гүйцэтгэх ажлын үе шат, хүргэх үр дүн	Төслийн нийт гүйцэтгэх хугацаа 6 сар байна. 1-3 сард: Эхлэл тайлан, өгөгдлийн экосистемийн үнэлгээ, их өгөгдлийн архитектурын загварын бичиг баримт, ETL хэрэгслүүд суурилуулалт, салбарын 360 хяналтын

		самбар, Нийгмийн даатгал, Халамж, Хөдөлмөр зуучлалын самбар хөгжүүлэлт 4-6 сард: Дараах гурван чиглэлд шаардлагатай үзүүлэлтүүдийг тодорхойлж бодит өгөгдөлд суурилан ахисан түвшний шинжилгээ хийж гүйцэтгэх • Гэр бүл 1. Гэр бүлийн үзүүлэлтүүд, түүний дүн шинжилгээ (Family Dynamics and Support) 2. Хүүхдийн хөгжил, хамгаалал (Child Development and Protection) 3. Орон сууц, гэр бүлийн байдал (Housing and Family Well-being) 4. Хүний хөгжил, амьдралын чанарын үзүүлэлтүүд, түүний дүн шинжилгээ (Human Development & Well-being) • Хөдөлмөр 5. Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт, түүний шинжилгээ (Labor Market Dynamics) 6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, хөдөлмөрийн эрхийн болон сонирхлын маргаан, хамтын гэрээ, хэлэлцээрийн мэдээлэл, түүний шинжилгээ (OSH) • Нийгмийн хамгаалал 7. Олон талт ядуурлын хэмжилт, шалгуур үзүүлэлтүүд (Multidimensional Poverty) 8. Халамжийн хүртээмж, үр дүнг тодорхойлох (Social Welfare and Social Protection) 9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний оролцоо ба хамгаалал (Disability Inclusion and Protection) 10. Нийгмийн даатгалын үзүүлэлтүүдийн үнэлгээ, салбарын үр дүн, Нийгмийн даатгалын хүртээмж, үр дүнг хэмжих үзүүлэлтүүд (Social Security Coverage)
5.	Туршилт, сургалт, нэвтрүүлэлтийн шаардлага	• Байнгын шинэчлэгддэг хяналтын самбар хөгжүүлэлтийн явцад туршилтыг тасралтгүй хийх бөгөөд эцсийн туршилтыг ажил хүлээлцэх бүрэлдэхүүнтэй хамт хийнэ. • Туршилт хийгдэж дууссаны дараа сургалтыг зохион байгуулна. • Сургалт нь танхим эсвэл цахим хэлбэртэй байж болно. Захиалагчид зориулсан гарын авлага, заавартай байна. • Гэрээгээр хүлээсэн бүх ажлыг актаар хүлээлцэх бөгөөд цаашид гэрээний дагуу засвар үйлчилгээ үргэлжлүүлж болно.
6.	Гүйцэтгэгчид тавигдах шаардлага	• Мэдээллийн технологи, программ хангамж хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байна.

		• Ижил төстэй үйлчилгээг сүүлийн 3 жилд хамгийн багадаа 2 удаа хэрэгжүүлсэн байх • Ижил төстэй ажил гэдэгт бодлогын шинжилгээ, нийгмийн салбарын үзүүлэлтүүдийн судалж дата анализ их өгөгдөл, дата мэдээллийн агуулах (Data Warehouse) үүсгэх, өгөгдөл шинжилгээний систем (Business Intelligence) систем нэвтрүүлэх гэрээг ойлгоно.
7.	Гүйцэтгэгч багт тавигдах шаардлага	Ерөнхий зөвлөх • Мэдээллийн технологийн чиглэлээр 15 жил ба түүнээс дээш ажилласан туршлагатай • Мэдээллийн технологи, эдийн засаг, бизнесийн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй • Мэдээллийн технологи, өгөгдлийн шинжилгээний чиглэлээр олон улсад зөвлөхийн үйлчилгээ үзүүлсэн туршлагатай • Их өгөгдөл нэвтрүүлэх 2-с доошгүй төсөл дээр ажилласан • Өгөгдлийн шинжилгээ, өгөгдөл боловсруулалт, стратеги боловсруулалт чиглэлээр олон улсын сертификаттай Шийдлийн дизайн боловсруулагч • Мэдээллийн технологийн чиглэлээр 10 жил ба түүнээс дээш ажилласан туршлагатай • Мэдээллийн технологи болон ижил төстэй чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй • Нийгмийн аль нэг салбарыг бүхэлд нь хамарсан Мэдээллийн технологийн төслүүд дээр ажиллаж байсан • Их өгөгдөл нэвтрүүлэх 3-с доошгүй төсөл дээр ажилласан • Өгөгдөл боловсруулалт, шинжилгээний технологиуд дээр олон улсын сертификаттай • Дэд бүтэц зохион байгуулалт, Kubernetes технологийн туршлагатай бөгөөд мэргэжлийн сертификаттай бол давуу тал болно Ахлах дата инженер • Мэдээллийн технологийн чиглэлээр 5 жил ба түүнээс дээш ажилласан туршлагатай • Мэдээллийн технологи болон ижил төстэй чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй • Нийгмийн аль нэг салбарыг бүхэлд нь хамарсан мэдээллийн технологийн төслүүд дээр ажиллаж байсан • Их өгөгдөл нэвтрүүлэх 2-с доошгүй төсөл дээр ажилласан • Өгөгдлийн сангийн архитектур, өгөгдөл боловсруулалтын технологиуд дээр олон улсын сертификаттай Дата инженер

		• Мэдээллийн технологийн чиглэлээр 2 жил ба түүнээс дээш ажилласан туршлагатай • Мэдээллийн технологи болон ижил төстэй чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй • Нийгмийн аль нэг салбарыг бүхэлд нь хамарсан мэдээллийн технологийн төслүүд дээр ажиллаж байсан • Их өгөгдөл нэвтрүүлэх 2-с доошгүй төсөл дээр ажилласан • Өгөгдөл боловсруулалтын чиглэлээр олон улсын сертификаттай Дата дүн шинжилгээ хийгч – 1 • Мэдээллийн технологийн чиглэлээр 5 жил ба түүнээс дээш ажилласан туршлагатай • Мэдээллийн технологи болон ижил төстэй чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй • Нийгмийн аль нэг салбарыг бүхэлд нь хамарсан мэдээллийн технологийн төслүүд дээр ажиллаж байсан • Их өгөгдөл нэвтрүүлэх 2-с доошгүй төсөл дээр ажилласан • Өгөгдлийн шинжилгээ, өгөгдөл хувиргалт болон холбогдох чиглэлээр олон улсын сертификаттай байх Дата дүн шинжилгээ хийгч – 2 • Мэдээллийн технологийн чиглэлээр 5 жил ба түүнээс дээш ажилласан туршлагатай • Мэдээллийн технологи болон ижил төстэй чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй • Нийгмийн аль нэг салбарыг бүхэлд нь хамарсан мэдээллийн технологийн төслүүд дээр ажиллаж байсан • Их өгөгдөл нэвтрүүлэх 2-с доошгүй төсөл дээр ажилласан • Өгөгдлийн шинжилгээ, өгөгдлийн засаглал болон холбогдох чиглэлээр олон улсын сертификаттай байх Тайлан хөгжүүлэгч – 1 • Мэдээллийн технологийн чиглэлээр 2 жил ба түүнээс дээш ажилласан туршлагатай • Мэдээллийн технологи болон ижил төстэй чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй • Тайлан хөгжүүлэлт, өгөгдлийн агуулах үүсгэх, нэвтрүүлэх 2-с доошгүй төсөл дээр ажилласан Тайлан хөгжүүлэгч – 2 • Мэдээллийн технологийн чиглэлээр 2 жил ба түүнээс дээш ажилласан туршлагатай • Мэдээллийн технологи болон ижил төстэй чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй • Тайлан хөгжүүлэлт, өгөгдлийн агуулах үүсгэх, нэвтрүүлэх 2-с доошгүй төсөл дээр ажилласан

		Төслийн зохицуулагч • Мэдээллийн технологийн чиглэлээр 10 жил ба түүнээс дээш ажилласан туршлагатай • Мэдээллийн технологи болон ижил төстэй чиглэлээр Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй • Нийгмийн аль нэг салбарыг бүхэлд нь хамарсан мэдээллийн технологийн 3-с доошгүй төсөл дээр ажиллаж байсан • Их өгөгдөл нэвтрүүлэх 2-с доошгүй төсөл дээр ажилласан • Мэдээллийн технологийн төслийн удирдлагын PSM (Professional Scrum Master) эсхүл дүйцэхүйц сертификаттай
8.	Хяналт, шалгалт	• Захиалгагч нь шаардлагатай бол гүйцэтгэлийн шатанд хяналт шалгалт хийнэ.
9.	Хүлээлгэн өгөх материал	• Гүйцэтгэлийн төлөвлөгөө, ерөнхий зураглал • Гэрээ, гэрээний гүйцэтгэлийн тайлан • Загварын сургалт, туршилтын үе шатны тайлан • Ашиглах гарын авлага • Сервер, сүлжээний тохиргооны заавар • Мэдээллийн аюулгүй байдлын тайлан
10.	Нөхцөл, болзол	• Зохиогчийн эрхийг Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эзэмшинэ. • Нууц хадгалах гэрээ байгуулна